

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 06/268

НШУС

2006

**ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН НИЙТЛЭЛИЙН БОДЛОГЫН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН АСУУДАЛД**

Ю.Эрдэнэтуюя\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

**Түлхүүр үг:** олон нийтийн телевиз, арилжааны телевиз, нэвтрүүлгийн төлөвлөлт, программын төлөвлөлт, креативын алба.

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль 2005 онд батлагдан гарснаар Монголын телевизийн тогтолцоонд нэгэн шинэ хэв маягийн телевиз бий болж, хөгжих эрх зүйн орчин бүрэлдсэн билээ. Үүний дагуу улсын телевизийн төрийн өмч олон нийтийн мэдэлд шилжиж, төржсөн телевиз бус, харин гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчлэх зорилго бүхий цоо шинэ телевиз болж өөрчлөгдөх үйл явц эхэлсэн юм. Энэ нь нэг амьсгаагаар шийдэх амар хялбар зүйл биш, тодорхой цаг хугацаа шаардсан амаргүй үйл явц гэдэг нь ойлгомжтой. Тиймээс өнөөдөр Монголын үндэсний олон нийтийн телевиз (MYONTV) шилжилтийн шатандаа явж, өөрчлөлт шинэчлэлтийн гараагаа эхлээд жил гаруй хугацаа өнгөрч байна.

Тэгвэл энэ хугацаанд хүмүүс Олон нийтийн телевиз гэж чухам юу болох, бусад телевизээс ямар ялгаатай болохыг сайн мэдэрч, энэ телевизийн идэвхтэй хэрэглэгч, үзэгч болж өөрчлөгдж чадаж байна уу? ОНТВ-ийн нэвтрүүлгийг нь үзэх гэж хүсэн хүлээж, түүний талаар бодол санаагаа илэрхийлэх гэсэн идэвх санаачилгатай, бас далайд дусал нэмэр ч гэсэн миний төлсөн хураамж юунд, яаж зарцуулагдаж, эргээд надад, үр хүүхдэд маань ямар хэрэгтэй зүйл юу өгч байгаад нь хяналт тавьж чаддаг үзэгчид болж өөрчлөгдөж чадаж байна? Эдгээр асуултын хариуг хамтдаа хайцгаая.

Уулзаж асуусан хүмүүсийн дийлэнх нь ОНТВ гэж учиргүй олон удирдлагатай, албан тушаалын халаа сэлгээ хийсэн газар юм уу даа гэсэн ойлголттой байлаа. Харин тэр олон удирдлага чухам юунд хэрэгтэй вэ, нийгмийн янз бүрийн бүлгийн эрх ашигийг төлөөлснөөр юу нь өөрчлөгдөө вэ гэдэг талаар төдийлөн сайн ойлголтгүй байгаа бөгөөд

энэ нь ч ОНТВ-ийн нийтлэлийн бодлогод нь тодорхой ялгарч харагдахгүй байна гэхэд хэлсдэхгүй бизээ. Тиймээс ОНТВ-ийн нийтлэлийн бодлогын үзэл баримтлал ямар байх ёстой талаар авч үзье.

Дэлхийн жишгээс харвал олон нийтийн телевиз нь хэд хэдэн төрөл хэлбэрээр оршин тогтнож үйл ажиллагаагаа явуулдаг боловч аль ч хэлбэрийн олон нийтийн телевизийн тухайд арилжааны болон улсын телевизээс ялгадах гол гурван онцлог байдаг гэж үздэг. Энэ нь:

Нэгдүгээрт, олон нийтийн эрх ашгийг төлөөлж, тэдний өмнөөс хяналт тавьдаг хараат бус удирдлагын тогтолцоотой байх,

Хоёдугаарт, олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн нийгмийн баримжаатай нийтлэлийн бодлоготой байх,

Гуравдугаарт, өвөрмөц эх сурвалж бүхий санхүүжилттэй байх явдал юм.

Эдгээрээс хоёрдугаар онцлог буюу нийтлэлийн бодлогын тухай асуудлын талаар ярья. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 3 дугаар зүйлд ОНРТВ-ийн зорилго, 8 дугаар зүйлд ОНРТВ-ийн хөтөлбөрийн бодлого, 9 дүгээр зүйлд ОНРТВ-ийн тусгай хөтөлбөрт тавигдах шаардлагын талаар

дэлгэрэнгүй заасан байгаа. Тодруулбал ОНРТВ-ийн зорилго нь гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээдэг, хяналт дор бүрийн мэдээлэл, сургалт, төрөл мэдэхүй, цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэж нийтийн хүртээл болгоход оршино гэж заажээ<sup>1</sup>.

Харин хөтөлбөрийн бодлого ардчилал, шудрага нь ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн олон ургальч узэл бодлыг илэрхийлсэн үндэсний соёл урлаг түүх, ёс заншил, уламжлалаа дээдэлсэн, хүний хөгжлий бүх талаар дэмжсэн, үндэсний цөөнх, эмзтэйчүүд, хүүхэд, хөгслийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн

*Олон шийтийн радио телевизийн зорилго нь гагцхүү олон шийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээдэг, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулж, төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэж шийтийн хүртээл болгоход оршино гэж заажээ*

»

булэг, давхрагын эрэлт, хэрэгцээг тэнцвэртэй хангасан байх ёстойг зааж өгч хуульчилсан байна<sup>2</sup>.

Эдгээр зорилго, бодлого, зарчмын өнгөц харвал аль ч телевизэд хамаатуулж болох нийтлэг шинжтэй юм. Гэхдээ онцолж үзэх хэдэн чухал зүйл байна. Үүнд:

- олон нийтэд үйлчлэх, тэдний эрх ашиг, хүсэл сонирхлыг илэрхийлэх,
- үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхлэх,

- нийгмийн янз бүрийн бүлэг давхрагын эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах,

- ашиг орлогын төлөөх зар сурталчилгааг хязгаарласан зэргийг дурьдаж болно.

Үүнээс харахад олон нийтийн телевизийн нийтлэлийн бодлогын үзэл баримтлал тодорхой байна. Гагцхүү үүнийг ямар аргаар, яаж хэрэгжүүлэх талаар тодорхой бодлого боловсруулж, түүнийгээ мөрдлөгө болгох асуудал чухал юм. МҮОНРТВ нийтлэлийн ийм тодорхой бодлого боловсруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Хийсэн зүйл ч багагүй байна. Нэвтрүүлгийн төлөвлөлт, креативын алба шинээр байгуулж, уран бүтээлчдээс 30 гаруй шинэ нэвтрүүлгийн захиалга авч "Монголын нэг өдөр", "Үл үзэгдэх нийгэм", "Алтан язгуур", "Тэнцэл" зэрэг долоон шинэ нэвтрүүлэг нээсэн, үзэгчдийн эрэлт хэрэгцээний судалгааг үндэсний хэмжээнд хийж буй зэрэг олон зүйлийг хэлж болно. Өөрчлөлтийн зарим эхлэл ч байна. Гэхдээ бусдаас нэг л сайн ялгарч өгөхгүй байна гэж би хувьдаа үзэж байгаа. Шалтгаан нь юунд байна? Нийтлэл нэвтрүүлгийн хувь хэмжээндээ байна уу, арга хэлбэртээ байна уу? гэдэг талцаар эргэцүүлж үзье.

МҮОНТ-ийн 2006 оны эхний хагас жилийн тайлангаас харахад хөтөлбөртөө 3 үндсэн зарчим баримталсан гэж тусгасан байгаа. Энэ нь:

Нийгмийн амьдралд тулгарч буй хамгийн тулгамдсан асуудлыг хөндөх

замаар тодорхой шийдлийг санал болгох,

Түүх, соёл, үндэсний нандин уламжлалыг олон нийт болон олон улсын тавцанд таниулан сурталчлах,

**X** үний хөгжлийг дэмжих замаар улс орны хөгжил дэвшил, эдийн засгийн өсөлт, олон нийтийн боловсрол, соёлыг хангахад чиглэгдсэн нэвтрүүлгүүд бэлтгэх гэжээ.

Харин дээрх зарчмаар боловсруулсан хөтөлбөрийн бүтцэд дараах өөрчлөлт гарчээ.

№	Төрөл	2005 оны 12-р сар	2006 оны 7-р сар	Зөрүү
1	Мэдээ, мэдээллийн	11.5 9	13.2	+ 1.2
2	Нийгэм, эдийн засгийн	10.8	7.9	- 2.9
3	Боловсрол, танин мэдэхүйн	8	9.4	+ 1.4
4	Түүх, соёл урлаг	21.4	6.4	- 15
5	Цэнгээнт	12	9.4	- 2.6
6	Кино	23.7	25	+ 1.3
7	Төлбөрт, захиалгат	31.7	28.7	- 3.0

Аль ч телевизийн нийтлэлийн бодлого нь программын төлөвлөлттэй салшгүй холбоотой байдаг. Программ төлөвлөлт нь тухайн телевиз, сувгийн удирдлагын бүхий функци зангидаагдж

байдаг телевизийн уран бүтээлийн менежментийн чухал хэсэг юм. Программ төлөвлөптийн бодлогын үндэс нь тухайн сувгийн агуулгын хийгээд уран бүтээпийн үзэп баримтлал болдог.

Бусад орны жишгээс харахад ОНТВ-ийн нийтлэлийн бодлогын ялгагдах нэг онцлог нь юуны өмнө арилжааны телевизүүд хөтөлбөртөө төдийлөн хангалттай хэмжээгээр тусгаж чаддаггүй тийм хөтөлбөр, нэвтрүүлгийн чиглэлийг бусдаас давуутай, түлхүү тусгаж чаддагт оршдог гэж үздэг. Энэ нь юу вэ гэвэл:

Нэг талаас, хүүхэд, ёсвөр үеийнхэн, хөгшид тэтгэвэрийнхэн, нийгмийн эмзэг бүлгийнхэн зэрэг төлбөрийн чадваргүй бүлгийнхэнд зориулсан нэвтрүүлгийн харьцааны үзүүлэлт байх.

Нэгээ талаас, тодорхой хэмжээний хөрөнгө, хүч зарж бэлтгэдэг, уран бүтээлийн даацтай, томоохон, бас чанартай, бие даасан бүтээлийн хэмжээг нэмэгдүүлэх асуудал байдаг байна. Үүнд тухайлбал, төлөжүжиг, төлө сериал, баримтат болон уран сайхны кино болон шинжлэх ухаан, танин мэдэхүйн цуврал бүтээлүүд ордог ажээ.

Өөр нэг асуудал бол бүх шатны сургалтын бие даасан хөтөлбөрийг

оловсролын хөгжлийн стратегитай уялдуулах замаар ОНТВ-ийн нийтлэлийн бодлогын нэгэн салшгүй бүрэлдэхүүн болгон авч үздэг байна. (Зарим газар бие даасан сувгууд хүртэл бий. Гэтэл манайд Боловсролын телевиз гарах юм гэнэлээ гэсэн сургаар энэ асуудлыг орхисон нь буруу юм.)

Эдгээрээс гадна манай ОНТВ-ийн нийтлэлийн бодлогод дутагдаж байгаа зарим зүйлийн талаар цөөн санал хэль:

- Ямар ч мэдээлэл,

ласааг тусгах, даа үзэл бодлын тэнцвэртэй байдлыг хангах, аль болох олон үзэл санааг уралдуулах замаар олон нийтийн эрх ашигт нийцүүлэх зарчмыг тууштай баримтлах (ялангуяа мэдээллийн хөтөлбөр хийгээд асуудал давшүүлсэн нэвтрүүлэгт),

*Бусад орны жишгээс харахад  
ОНТВ-ийн нийтлэлийн бодлогын  
ялгагдах нэг онцлог нь юуны  
өмнө арилжааны телевизүүд  
хөтөлбөртөө төдийлөн  
хангалттай хэмжээгээр  
тусгаж чаддаггүй тийм  
хөтөлбөр, нэвтрүүлгийн  
чиглэлийг бусдаас давуутай,  
түлхүү тусгаж чаддагт оршдог  
гээж үздэг.*

»

- Нийгмийн тулгамдсан асуудлыг хэлэлцүүлэхдээ иргэний нийгмийн булгүүд, ТББ-уудын идэвхтэй оролцог хангахад түлхүү анхаарах,

- Асуудлыг улс төржүүлэхгүй байх (манайд асуудал хариуцсан тодорхой албан тушаалтнуудыг аль болох оролцуулж тухайн нэвтрүүлгээрээ уг асуудлыг шийдүүлчихгээд зүтгээд байдаг, бас тулгамдсан асуудал хөндөхөөрөө заавал дээшээ, шийдвэр гаргаг-

чид руу хандуулдаг зуршил тогтсон. Энэ ч буруу зүйл биш, гэхдээ зарим асуудлыг хөндөхдөө, жишээ нь ядуурал, ажилгүйдэл ч гэдэг юм уу асуудлын талаар гэхэд энэ асуудлыг шийдэхэд иргэд, олон нийт өөрсдөө юу хийж чадах, яаж оролцож болох талаар болон зарим зэрэг, ололттой талыг харуулах нь багагүй ач холбогдолтой гэж үзэж байна. Жирийн, дундач иргэний амжилт, түүнд хүрсэн аргыг сурталчлах нь олон нийтэд "би ийм болж чадах юм байсан" гэсэн итгэлийг төрүүлж болохоороо нийгмийн хөгжилд үнэ цэнэтэй гэж үздэг).

**O**рон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг үндэсний телевизийн хэмжээнд гаргаж тавихад анхаарлаа хандуулах учиртай. Бүсчилсэн хөгжил, Хот дагасан их нүүдэл, хөдөөгийн хүн ардын боловсрол, эрүүл мэндийн асуудал зэрэг олон зүйлийг хэлж болно.

Хүн төрөлхтний хөгжлийн глобаль асуудал болох экологи, шинэ дэвшилтэй технологи, эрүүл хүнс гэх мэт асуудлыг нийтлэлийнхээ бодлогын төвд байлгах асуудал чухал байна.

Эцэст нь тэмдэглэхэд ОНТВ бол миний эрх ашгийг хамгаалдаг, надад үйлчилдэг телевиз юм гэж ханддаг, найдаг үзэгчдийн өргөн хүрээг буй болгоход анхаарах шаардлагатай. Яагаад гэвэл ОНТВ-ийн арилжааны телевизээс ялгагдах бас нэг онцлог нь аудитори буюу хэрэглэгч/үзэгчдэд хандах хандлага юм. Арилжааны

сувгийн тухайд гэвэл гол төлөв аудиторийг өөрийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд дам нөлөө үзүүлэгч субъект гэж үздэг учраас иргэний идэвхийг нэг их гол болгодоггүй, харин ОНТВ-ийн аудитори нь ашиг сонирхлоо хамгаалсан, түүнийхээ төлөө тэмцдэг, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг шүүмжилдэг, нийгмийн идэвхтэй үзэгчид болж чаддагаараа ялгаатай байдаг.

Мэдээллийн зах зээл дэх телевизүүдийн ширүүн өрсөлдөөний явцад ОНТВ өөрийн хөтөлбөрөөрөө ялгарч, өөрийн гэсэн үзэгчидтэй болно гэдэгт итгэлтэй байна.

## Ишлэл

<sup>1</sup> ОНРТВ-ийн хууль.

<sup>2</sup> ОНРТВ-ийн хууль.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

- Д о ж о од о р ж Д., Ш а р а в д о р ж Н., Ч о й ж и л М., Ц э д э в с ү р э н Д., Ж а н д а л Ц. 1997. Зурагт зулын хойморт мөнхөрсөн нь. УБ.
- М е н ч е р М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.
- Н а р а н ж а р г а л Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
- Ц в и к В. 2004. Телевизионная журналистика. М.
- В I о с к М. 1987. Writing Broadcast News. Bonus Books Inc.